



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 04 дугаар сарын 27

Дугаар 15/02

Баян-Өндөр сум

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.6, 20.1.7, 20.1.9, 20.1.18, 20.1.21, 20.1.22, 35 дугаар зүйлийн 35.1.13, 35.1.15 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Эрдэнэт хотын 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг нэгдүгээр, аймгийн Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн Засаг дарга С.Батжаргалд ДААЛГАХ нь:

2.1.Өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулж ажиллуулах;

2.2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж, явцын талаарх мэдээллийг 2023 оны 08 дугаар сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд танилцуулах.

ДАРГА



Д.МӨНХБАТ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны  
04 дүгээр сарын 28-ны өдрийн Ээлжит XV хуралдааны  
15% дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

### ЭРДЭНЭТ ХОТЫН 2023-2024 ОНД ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зохион байгуулж, хэрэгжүүлэх байгууллага	Төсөвт өртөг (төгрөг)	Хөрөнгийн эх үүсвэр (тайлбар)
1	Баянцагаан баг. Дулааны төв шугам сүлжээний Ф720x8.0мм-ийн шугамын өргөтгөлийн ажил	II-IV улирал	ГХБХБГ, ХЗА, "ЭДЦС" ТӨХК,	4,338,969,434	Барилга хот байгуулалтын яам
2	Цагаанчулуут, Наран багт ус дулаан дамжуулах төв барих, төв дулаан, цэвэр усны шугам сүлжээний өргөтгөл хийх ажил	II-IV улирал	ГХБХБГ, ХЗА, "ЭДЦС" ТӨХК,	4,362,361,049	Барилга хот байгуулалтын яам
3	Орхон аймгийн төв Баян-Өндөр сумын 6/0.4кВ-ын цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх, сайжруулах ажил	II-IV улирал	"ЭБЦТС" ТӨХК, "Ричвелл инженеринг" ХХК	12,790,000,000	Дэлхийн банкны санхүүжилтээр
4	Европын сэргээн босголт хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хийгдэх "Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал" төслийн ажил	II-IV улирал	АЗДТГ, ХЗА, ХББЗА, Төслийн нэгж	54,278,000,000	Европын сэргээн босголт хөгжлийн банкны хөрөнгө
5	Уурхайчин хорооллууд, 1А хорооллын 35/6кВ ЦРП-2 дэд станцын өргөтгөл	II-III улирал	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, ХББЗА	1,838,000,000	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
6	Инженерийн шугам сүлжээний шинэчлэлтийг үе шаттайгаар үргэлжлүүлэн хийх, зайлшгүй шаардлагатай шугам сүлжээний шинэчлэлтийн ажил (9 ажил)	II-III улирал	ХББЗА, Баян-Өндөр, Жаргалант сум	2,706,099,100	Барилга хот байгуулалтын яам, Орон нутгийн төсөв, Жаргалант сумын хөрөнгө оруулалт
7	Орон сууцны болон гэр хорооллын гудамжинд гэрэлтүүлэг хийх (14 ажил)	II-III улирал	ХЗА, ХББЗА, Баян-Өндөр, Жаргалант сум	1,777,992,300	Орон нутгийн төсөв, Баян-Өндөр, Жаргалант сумдын хөрөнгө оруулалт
8	Хатуу хучилттай болон шороон замын засварын ажлыг үргэлжлүүлэн хийх, туузан хашлага хийх, хэвтээ тэмдэг тэмдэглэгээ хийх (29 ажил)	II-III улирал	ХЗА, ХББЗА, Баян-Өндөр, Жаргалант сум	6,166,578,490	Орон нутгийн төсөв, Баян-Өндөр, Жаргалант сумдын хөрөнгө оруулалт

9	Орон нутгийн чанартай авто замын халтиргаа гулгаанаас хамгаалах зорилгоор хайрга, давс, бодис, машин механизм шатах тослох, материал, тусгай шингэн хүрэлцэхүйц хэмжээгээр нөөцлөх, шуурхай алба ажиллуулах	II-III улирал	Хот тохижуулах газар, Жаргалант сум	269,500,000	Орон нутгийн төсөв, Жаргалант сумын хөрөнгө оруулалт
10	Хотын доторх авто замын тэмдэг, тэмдэглэгээ, нөхөөс, хүйтэн асфальт, засвар үйлчилгээний зардал	I-IV улирал	ХЗА, ХББЗА, Жаргалант сум, Хот тохижуулах газар "Орхон Азза" ТӨХК	509,000,000	Орон нутгийн төсөв
11	A1001, A1002 улсын чанартай авто замын аюулгүй байдлыг хангах зорилгоор эвдрэл үүссэн хэсгийг засварлаж, нөхөөс хийх, засвар үйлчилгээний зардал, бэлэн байдлыг ханган ажиллах шуурхай ажлын хэсгийн зардал	II-III улирал	"Орхон Азза" ТӨХК	1,101,305,000	Улсын төсвийн хөрөнгөөр
12	Хог хаягдлын менежментийг сайжруулахад тусгай зориулалтын машин, тоног төхөөрөмж худалдан авах	II-IV улирал	АЗДТГ, Хот тохижуулах газар	2,355,000,000	Орон нутгийн төсөв
13	Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн хүрээнд автобус худалдаж авах (6 ширхэг)	I-IV улирал	Аймгийн ЗДТГ, Авто тээврийн төв	1,110,000,000	Орон нутгийн хөрөнгө оруулалт
14	Агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөөний хүрээнд шахмал түлшний үйлдвэрийн барилга барих (Орон нутгийн оролцооны зардал)	II-IV улирал	АЗДТГ	1,500,000,000	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
15	Сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагуудын шугам сүлжээний найдвартай ажиллагааг хангах. Нам даралтын зуухаар халдаг сургууль, цэцэрлэгүүдийн халаалтын шугам сүлжээний бэлэн байдлыг хангаж он дуустал нүүрс татан авалт, нөөцлөх ажлыг зохион байгуулах.	III-IV улирал	ХЗА, СТСХ, БШУГ	335,000,000	Орон нутгийн төсөв
				<b>95,437,805,373</b>	
<b>Нийт</b>					
<b>Хөрөнгийн эх үүсвэр шаардлагатай ажлууд</b>					
16	Шанд баг. 17-р сургуулийн халаалтын зуухыг шинэчлэх	II-III улирал	АЗДТГ, ХЗА, БСУГ	276,036,600	Хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэх
17	20-р сургуулийн гадна суурилуулсан узелд барилга барих	II-III улирал	АЗДТГ, ХЗА, БСУГ	96,000,000	Хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэх

18	Кувейтын гудамжинд байрлалтай төв цэвэр усны шугамын ажил	II-III улирал	АЗДТГ, ХЗА, БСУГ	121,454,130	Хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэх
19	Эко хорооллын дулаан хангамжийн шугам сүлжээг хэсэгчлэн солих	II-III улирал	АЗДТГ, ХЗА, "ЭУДТС" ОНӨХК	543,782,844	Хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэх
<b>Нийт</b>				<b>1,037,273,574</b>	
<b>Тухайн байгууллагын дотоод зохион байгуулалт, өөрийн хөрөнгөөр хийх ажил</b>					
20	"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК 2023 оны 10 дугаар сарын 1-ний дотор 24'500 тонн нүүрс нөөцлөх.	II-IV улирал	"ЭДЦС" ТӨХК	29,007,000,000	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
21	Зуух №3, №4-ийн их засварын ажил	II-III-р улирал	"ЭДЦС" ТӨХК	3,100,000,000	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
22	Үнсэн сан №1-ийн үнсийг хоосолж, даланг өндөрлөх ажил	II-IV улирал	"ЭДЦС" ТӨХК	5,000,000,000	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
23	Их засвар, ТЗБАХ, ХО-ийн төлөвлөгөөт ажлыг график хугацаанд хийж гүйцэтгэх	II-IV улирал	"ЭДЦС" ТӨХК	7,806,500,000	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
24	Дэнжийн 3-р байрны 0.4кВ-ын кабель шугам, 6/0.4кВ-ын ХТП-3 дэд станцын 0.4кВ-ын хуваарилах байгууламж, 35/6кВ-ын ЦРП-9 дэд станц, 6/0.4кВ-ын АТП-13, 289, 428 дэд станцуудын их засварын ажил	II-III улирал	"ЭБЦТС" ТӨХК	138,107,200	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
25	Эрдэнэ багт баригдах 35кВ-ын нэг хэлхээт төмөр бетон тулгууртай ЦДАШ барих ажлыг дуусгах	II-III улирал	"ЭБЦТС" ТӨХК	322,447,600	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
26	Хуучин 35/6кВ-ын ЦРП-8 дэд станцыг Эрдэнэ баг руу шилжүүлэх	II-IV улирал	"ЭБЦТС" ТӨХК	251,254,000	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
27	Хүчдэлийн уналт үүссэн газруудад дэд станц барьж, 0.4кВ-ын ЦДАШ барьж цахилгаан хангамжийг сайжруулах	III-IV улирал	"ЭБЦТС" ТӨХК	164,412,100	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
28	6/0.4кВ-ын АТП-42 дэд станцын хүчин чадлыг нэмэгдүүлж 0.4кВ-ын ЦДАШ-д засвар хийх, 6/0.4кВ-ын ХТП-276 дэд станцын ачааллыг хувааж дэд станц нэмж барих, 6/0.4кВ-ын ХТП-239 дэд станцуудын 0.4кВ-ын оруулгад АВР суурилуулах	II-III улирал	"ЭБЦТС" ТӨХК	93,207,700	Байгууллагын хөрөнгө оруулалтаар

29	Орон сууцны байрнуудын халаалт, халуун, хүйтэн усны оруулгын шугам шинэчлэх, гадна цэвэр усны шугам шинэчлэх ажил	II-III улирал	"ЭУДТС" ОНӨХ	118,100,000	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
30	Гэр хорооллын ус түгээх байранд ухаалаг төхөөрөмж суурилуулах, урсгал засварын ажлуудыг хийх.	II-IV улирал	"ЭУДТС" ОНӨХ	152,800,000	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
31	Ус, дулаан хуваарилах төвүүдэд шаардлагатай халаалт, хэрэглээний халуун хүйтэн усны насосууд болон хаалтууд шинэчлэх. Цахилгааны шитүүдэд урсгал засвар хийх.	II-IV улирал	"ЭУДТС" ОНӨХ	127,570,000	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
32	Орон сууцны 75ш байрнуудын шитийн урсгал засвар, дэд станцуудын урсгал засварын ажил. Хотын доторх хаалттай дэд станцуудын дээвэр хаалга засварлах	I-IV улирал	"ЭУДТС" ОНӨХ	74,210,000	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
33	Хотын доторх гэмтэлтэй бохир усны шугамыг хэсэгчлэн шинэчлэх, орон сууцны подвалын бохир усны шугамыг шинэчлэх, Танил захын урд талын КНС-д шугам хэсэгчлэн солих, худаг гаргах	II-IV улирал	"ЭУДТС" ОНӨХ	64,750,000	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
34	Нийтийн орон сууцны байрнуудын орцонд вакум цонх хийх, соронзон цоожтой хаалга хийх, дээвэр засвар хэсэгчилж хийх, давхар дундын цахилгааны шитийн засварын ажил, орцны засварын ажил, подвалын ариутгал, халдваргүйтгэл, хортон шавьж устгалын ажлыг хийх	II-IV улирал	Сууц өмчлөгчдийн холбоод, Баян-Өндөр сум	683,956,000	Байгууллагын хөрөнгө оруулалтаар
35	Халаалтын улирал эхлэхээс өмнө орон нутгийн өмчийн барилга болон сургууль, цэцэрлэгийн цонх, хаалгыг дулаалах, заадас, хаяавч засварлах, дулааны үзель болон халаалтын шугамыг угаах засварлах.	II-III улирал	Орон нутгийн өмчийн газар, Нийтлэг үйлчилгээний алба, БШУГ, Сургууль, цэцэрлэгийн захиргаа.	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
36	Баян-Өндөр, Жаргалант сумдын гэр хорооллын айл өрхүүдийн түлшний модоор хангах ажлыг зохион байгуулах	II-III улирал	БОАЖГ, ХОХБТХ Баян-Өндөр, Жаргалант сум	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах



37	Орон сууцны болон гэр хорооллын гудамж, талбайн гэрэлтүүлгийн хэвийн ажиллагааг хангах	Тогтмол	ХЗА, АЗДТГ, Баян-Өндөр сум, "ЭУДТС" ОНӨХК	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
38	Дулааны төв шугамын нягтын туршилтыг гаргасан программын дагуу 2 удаа хийж гарсан гэмтлийг бүрэн засварлах, шаардлагатай тоног төхөөрөмж, шугам сүлжээний засварын ажлыг бүрэн зогсолтын үед хийж гүйцэтгэх	II-III улирал	ХЗА "ЭДЦС" ТӨХК, "ЭУДТС" ОНӨХК	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
39	Өнгөрсөн жилийн халаалтын улиралд ихээхэн гомдол ирсэн айл өрх, аж ахуй нэгж байгууллагуудаар үзлэг шалгалт хийх, илэрсэн зөрчил, доголдлыг арилгах	II-III улирал	ХЗА, "ЭДЦС" ТӨХК, "ЭУДТС" ОНӨХК, Баян-Өндөр, Жаргалант сум	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
40	Зөвшөөрөлгүй дулааны холболт хийсэн айл өрх, аж ахуй нэгж байгууллагуудад хамтарсан үзлэг шалгалт хийж, халаалтын горим алдагдуулж байгаа газруудын хэвийн ажиллагааг хангуулах	II-III улирал	ХЗА, "ЭДЦС" ТӨХК, "ЭУДТС" ОНӨХК, ГХБХБГ, Баян-Өндөр сум	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
41	Орон сууцны байрнуудын дулааны узельд шайб саплоны тохируулга хийх, ус дулаан хуваарилах төвүүдийн тоног төхөөрөмж, дулаан солилцооны найдвартай ажиллагааг хангах	III улирал	"ЭДЦС" ТӨХК, "ЭУДТС" ОНӨХК	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
42	Тухайн байгууллага өөрийн харьяа инженерийн байгууламж, шугам сүлжээнд доголдол, гэмтэл гарсан тохиолдолд хэрэглэх сэлбэг материал, тоног төхөөрөмж, машин механизмын бэлэн байдлыг хангах	I-IV улирал	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "ЭБЦТС" ТӨХК, "ЭДЦС" ТӨХК, "ЭУДТС" ОНӨХК, "МХС" ХХК	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
43	Үерийн усны далан сувгийг бүрэн цэвэрлэх, улирал бүр үзлэг шалгалтыг хийж сувгийг сэргээн хэвийн ажиллагааг хангаж ажиллах	Улирал бүр	ХЗА, Баян-Өндөр, Жаргалант сум, Онцгой байдлын газар, Хот тохижуулах газар	-	Байгууллагууд хамтарч ажиллах
44	Гэр хорооллын болон орон сууцны хорооллын борооны ус зайлуулах суваг, халаалт, цэвэр, бохир ус, холбооны худгуудыг цэвэрлэх, лийдах засвар үйлчилгээ хийж, худгуудын тагны бүрэн бүтэн байдлыг хангах	II-III улирал	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "ЭДЦС" ТӨХК, "ЭУДТС" ОНӨХК, Хот тохижуулах газар, "МХС" ХХК, Баян-Өндөр, Жаргалант сум	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах

45	Аймгийн хэмжээнд цахилгаан, холбооны агаараар татагдсан инженерийн шугам сүлжээнд үзлэг хийж унжилт ихтэй шугамыг татах, илэрсэн зөрчлүүдийг арилгах	II-III улирал	ХЗА, "ЭБЦТС" ТӨХК, "ЗУДТС" ОНӨХК, "МХС" ХХК, Баян-Өндөр, Жаргалант сум	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
46	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа сургууль, цэцэрлэг, багийн байр, соёлын төвийн барилгуудын ажлыг эрчимжүүлэх	I-IV улирал	АЗДТГ, ХЗА, ХББЗА	-	Улсын төсвийн хөрөнгөөр
47	Хэрэглэгчдэд эрчим хүчийг хэмнэлттэй "Ногоон барилга"-ыг сурталчлах, орон сууцны хорооллын байрны дулаан алдагдлыг бууруулах талаар мэргэжлийн заавар, зөвлөгөө, зөвлөмж өгөх	I-IV улирал	АЗДТГ, ХББЗА, "ЭДЦС" ТӨХК, "ЭБЦТС" ТӨХК, "ЗУДТС" ОНӨХК, Хэвлэл мэдээллийн алба	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
48	Хот хооронд болон аймаг хооронд зорчигч тээврийн үйлчилгээнд гарч буй тээврийн хэрэгслүүдийн бэлэн байдлыг хангуулах, үзлэг шалгалтыг эрчимжүүлж, "Тээвэрлэгч бид өвөлд бэлэн" өдөрлөгийг зохион байгуулах	III-IV улирал	Авто тээврийн төв	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
49	Цаг агаарын аюултай үзэгдэл болон гамшгийн сэрэмжлүүлэг, урьдчилан сэргийлэх мэдээг иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад шуурхай мэдээлж ажиллах	Тогтмол	Онцгой байдлын газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, Баян-Өндөр, Жаргалант сум	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулах
<b>Нийт</b>				<b>47,104,314,600</b>	



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны  
04 дүгээр сарын 28-ны өдрийн Ээлжит-XV хуралдааны  
15/02 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ОРХОН АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН 2023-2024 ОНЫ ӨВӨЛЖИЛТ,  
ХАВАРЖИЛТЫН БЭЛТГЭЛ ХАНГАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гүйцэтгэх ажил	Хугацаа	Зохион байгуулах, хэрэгжүүлэх байгууллага	Төсөвт өртөг (сая.төг)	Хөрөнгийн эх үүсвэр	Хүрэх үр дүн
<b>Нэг. Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангах талаар:</b>						
1.	Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөг батлуулж, биелэлтэд хяналт тавих, дүн мэдээг ХХААХҮЯ-нд хүргүүлэх	II -IV улиралд	ХБТХОХ, ХХААГ, НДХ, ЭМГ, МЭГ, сумдын ЗДТГ	5,7	ОНТ	3 удаа малчдын хотонд очиж төрийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулна. Засгийн газрын тогтоолын дагуу өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг малчин өрх, баг, сумын түвшинд хангаж, хүлээн авна.
2.	Өвс, тэжээлийн нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах /ЗГ-ын тогтоолоор батлагдсан төлөвлөгөөний дагуу бэлтгэх/	III-IV улиралд	ХХААГ, ОБГ, сумдын ЗДТГ	175,0	ОНТ	Жаргалант сум 50.0сая/төг Баян-Өндөр сум 50.0 сая/төг Аймгийн төсөвт 75.0 сая/төгрөг буюу нийт 175.0 сая/төгрөгөөр өвс тэжээлийн нөөц бүрдүүлнэ.
3.	Өвөлжөө, хаваржааны тодорхой бүс нутаг, таримал ургамлын талбайг малаас хамгаалах, чөлөөлөх ажлыг зохион байгуулах	II-III улиралд	Жаргалант сумын ЗДТГ	-	ОНТ	Жаргалант сумын Засаг даргын захирамж гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллана.
4.	Малчин, мал бүхий иргэнээр байгалийн хадлан, гар тэжээл бэлтгэх ажлыг технологит хугацаанд нь чанартай гүйцэтгүүлэх, өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх	III улиралд	Сумдын ЗДТГ, Малчин баг, мал бүхий багууд	-	-	ХХААГ, сумдын ЗДТГ-аас малчин болон мал бүхий иргэдэд мэдээлэл тогтмол хүргэх, арга зүйн зөвлөгөө өгч ажиллана. Жаргалант сумын ЗДТГ-ын хадлангийн техникийг хөнгөлөлттэй



							нехцөлөөр ашиглуулах боломжийг бүрдүүлнэ.
5.	Хадланчдад талбай олгуулах, мал өвөлжүүлж, хаваржуулах, нутаг бэлчээр ашиглуулах асуудлаар хил залгаа аймаг, сумдтай хамтарч ажиллах	II-III улиралд	ХХААГ, сумдын Засаг дарга нар	0,2	ОНТ		Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн, Орхонтуул Булган аймгийн Бугат, Хангал, Сэлэнгэ, Орхон сумдын удирдлагуудтай уулзалт хийж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллана.
6.	Малчин өрхүүд малын хашаа байраа сэлбэн засах, түлээ, түлш, өтөг бууц нөөцлөх, хөрсөн гаргах, сийрүүлэх арга хэмжээ авах	II-III улиралд	Сумдын ЗДТГ, багийн Засаг дарга нар	-	-		Малчдын түвшинд хийгдэнэ. Арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.
7.	Цаг агаарын аюултай үзэгдэл болон гамшгийн сэрэмжлүүлэг, урьдчилан сэргийлэх мэдээг шуурхай гаргаж, мэдээллийг мал аж ахуй эрхлэгчдэд шуурхай хүргэх	Тухай бүр	УЦУОШТ, ХХААГ, сумдын ЗДТГ	-	-		ОБГ, УЦУОШТөв-өөс цаг агаарын мэдээг тогтмол авч сумдын ЗДТГ болон ХХААГ-ын раге хаягаар шуурхай хүргэх ажлыг зохион байгуулна.
8.	Зуншлагын цагийн байдалтай танилцаж, үнэлэлт, дүгнэлт гаргаж ажиллах	III улиралд	УЦУОШТ, ХХААГ, сумдын ЗДТГ	-	-		Зуншлагын байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх ажлын хэсгийг ХХААГ-ын даргын тушаалаар байгуулж ажиллана.
9.	Өвөлжих болон хэрэгцээлэх малын тоог малын төрөл, сургийн зохистой харьцаанд тохируулан сум, багаар нэгтгэн гаргах, эдийн засгийн эргэлтэд оруулах, орон нутагтаа болон отроор өвөлжиж, хаваржих малчид болон малын судалгааг нарийвчлан гаргах	III улиралд	ХХААГ, сумдын ЗДТГ	-	-		Малчдыг эргэх ажлын хүрээнд тодорхой мэдээлэл авч нарийвчилсан судалгааг гаргана. Аймгийн хэмжээнд мах бэлтгэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, иргэдтэй холбож өгөх ажлыг зохион байгуулна.
10.	Малыг үзлэг ангилалт, хянан баталгаажуулалтад бүрэн хамруулах ажлыг цаг хугацаанд нь чанартай зохион байгуулах, ажлын үр дүн, тайлан мэдээг холбогдох газруудад хүргүүлэх	II-IV улиралд	ХХААГ, сумдын ЗДТГ	8,0	ОНТ		Хавар болон намар 2 удаа мал ангилах, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулна. Нийт 37.5 мянган толгой мал хамруулна.

11.	Бэлчээрийн худаг уст цэгийн бэлэн байдлыг хангах, шинээр гаргах буюу засварлах ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэх	II-IV улиралд	ХХААГ, Жаргалант сумын ЗДТГ	60,0	УТ, Жаргалант сумын ОНТ	ХХААХУЯ-аас зарласан тендэрт БИММ ХХК шалгарсан. Тус компани нь Жаргалант сумын Жаргалант, Хөндлөн намаг гэдэг газар худаг шинээр гаргах бөгөөд тус худгийг гаргаснаар 26 өрхийн 5420 толгой мал усаар хангагдах боломжтой болно.
12.	Цаг агаарын байдал хүндэрсэн тохиолдолд малчдад хүнс, өвс тэжээл хүргэх, даваа, гүвээ засах, цас ярагч техник хэрэгсэл, туулах чадвартай машины бэлэн байдлыг хангах	I, IV улиралд	ХБТХОХ, ХХААГ, сумдын ЗДТГ	-	ОНТ	Цаг агаарын нөхцөл байдалтай холбогдуулан аймгийн Онцгой комиссстой хамтран ажиллана.
13.	Малчин өрхийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг шалгаж хүлээн авах ажлыг зохион байгуулах	III улиралд	ХХААГ, сумдын ЗДТГ	-	ОНТ	Аймгийн хэмжээнд мал өвөлжилт, хаваржилтын бэлтгэл, зохион байгуулалтын мэдээ, тайланг ХХААХУ-ийн Сайдын 2016 оны А/71 дүгээр тушаалын дагуу малчин өрхийн түвшинд 8 үзүүлэлт, сумын түвшинд 6 үзүүлэлт, аймгийн хэмжээнд 7 үзүүлэлтээр тус тус дүгнэж, хэрэгжилтийг 10-р сарын 15-ны дотор ХХААХУЯ-ны МААБХЗГ-т тайлагнана.
<b>Хоёр. Мал эмнэлгийн ажил үйлчилгээний чиглэлээр:</b>						
14.	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй махны үйлдвэр, мах, махан бүтээгдэхүүн худалдан борлуулдаг аж ахуйн нэгж болон сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсэнд нийлүүлэгдэж буй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд хүнсний чанар, аюулгүй байдлын шинжилгээг мал эмнэлэг, ариун цэврийн лабораторид хийж, хяналт тавин үр дүнг тайлагнах	Тухай бүр	ХХААГ, МЭГ	18,5	ОНТ	Мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүн, антибиотик, пестицидийн үлдэгдлийг тодорхойлох, малын эмийн зохистой хэрэглээг ханган ажиллана. Шаардагдах зардлыг орон нутгийн төсвийн тодотголд оруулахаар санал хүргүүлсэн.

15.	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 11.1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоолын 2-р хавсралтанд заасан 4 төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины үнэ, үйлчилгээний хөлсийг орон нутгийн төсөвт тусгуулж хэрэгжилтийг хангаж ажиллах	II-IV улирал	Аймгийн ЗДТГ-ын СТСХ, МЭГ, МЭ-ийн Тасаг, МЭУ-ийн нэгж	36,3	ОНТ	Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин тарилгад аймгийн хэмжээнд 111.7 мянган толгой мал, амьтныг хамруулна. Вакцин тарилгын үнэ, үйлчилгээний хөлсийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.
16.	Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тандалт шинжилгээ хийх/шүлхий, бог малын мялзан, үхрийн арьс товруутах/	II-III улирал	МЭГ, УМЭАЦТЛ МЭ-ийн лаборатори	3,2	УТ	Мал, амьтныг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулна. Бог малын мялзан, үхрийн арьс товруутах өвчний халдварын хүрээг тогтоох тандалтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулна. Шүлхий өвчийг эрт илрүүлэх тандалт шинжилгээ, вакцинжуулалтын дараах мониторинг хийж ажиллана.
17.	Мал, амьтны сэг, зэм устгах, малчдын өвөлжөө, хаваржааг ариутгах, халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулах	II-IV улирал	МЭГ, сумдын ЗДТГ	14,2	ОНТ	Аймгийн хэмжээнд орчны эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, сэг зэм устгал, худаг уст цэг, бэлчээрийн халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулж ажиллана.
<b>Гурав. Газар тариалангийн бэлтгэл хангах талаар:</b>						
18.	Тариалалт, уринш боловсруулалтын ажлыг технологийн зохистой хугацаанд чанартай гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх, хяналт тавьж ажиллах.	I, II улирал	ХХААГ	2,0	ОНТ	Аймгийн хэмжээнд 5 аж ахуйн нэгж 4000 га талбайд уринш хийнэ. Хөнгөлөлттэй нөхцөлөөр олгогдох гребцидийн захиалгыг аж ахуйн нэгжүүдээс авч ХХААХҮЯ-нд хүргүүлнэ. Уринш боловсруулалтын явцад хяналт тавьж ажиллана.
19.	Бордоо, ургамал хамгааллын бодисын зохистой хэрэглээг төлөвшүүлэх, таримлын зөв сэлгээг нэвтрүүлэх замаар хөрсний үржил шимийг хамгаалах	I, II улирал	ХХААГ, сумдын ЗДТГ	-	-	Аймгийн малчид, тариаланчдын зөвлөгөөн зохион байгуулж ургамал хамгаалал, тариалалтад сэлгээг зөв хэрэглэх, хөрсний үржил шимийг

							дээшлүүлэх талаар сургалт зохион байгуулж, ургалтын хугацаанд хяналт тавьж зөвлөгөө өгч ажиллана.
20.	Ургац хураалтын ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, шуурхай зохион байгуулах, аж ахуйн нэгж, айл, өрх, иргэдийн хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний ургацын мэдээг үнэн зөв, шуурхай гарган холбогдох газруудад танилцуулах, тайлан мэдээг хүргүүлэх	III, IV улирал	ХХААГ, сумдын ЗДТГ	1,0	ОНТ		Аймгийн Засаг даргын захирамжаар ургац хураалтын ажлыг зохион байгуулах комисс байгуулж ажиллана. 2 сумын Хөдөө аж ахуйн тасгаар дамжуулан ургац хураалтын мэдээг тогтмол авч улсын ургацын төв штабт хүргүүлэх ажлыг зохион байгуулна.
21.	Намрын ургац хураалтын ажилд шаардагдах шатахууны нөөцийг бүрдүүлэх, цахилгаан эрчим хүчээр тасралтгүй, найдвартай хангах арга хэмжээ авч ажиллах	III улирал	ХХААГ, "ЭБЦТС" ТӨХК	-	-		Аймгийн хэмжээнд ургац хураалтад шаардагдах шатахууны тооцоог гаргаж ХХААХҮЯ-нд хүргүүлнэ. Тариаланчдад хөнгөлөлттэй үнээр болон зээлээр шатахуун олгох ажлыг зохион байгуулна.
22.	Ургац тээвэрт ашиглагдах зам гүүрний эвдрэл, гэмтлийг шалгаж тодруулах, шаардагдах хөрөнгийн тооцоог гаргаж эх үүсвэрийг нь шийдвэрлүүлэн засварын ажлыг шуурхайлах, төмөр замаар тээвэрлэгдэх ургац тээвэрлэлтэд саатал гаргахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авах	III улирал	ХЗА	-	-		Цаг үеийн нөхцөл байдлыг газар дээр нь шалгаж ажиллана. Шаардлагатай тохиолдолд аймгийн Онцгой комисст асуудлыг танилцуулж шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлүүлж ажиллана.
23.	Сортын үрийн хянан баталгааг хугацаанд нь хийж дуусгах, дараа оны тариалалтад нөөцлөх үрийн цэвэрлэгээг шалгаж стандартад тэнцүүлэх, ногооны зoorь, агуулах, үгрэмийн цэвэрлэгээ ариутгал, бүтээгдэхүүний хадгалалтад хяналт тавьж ажиллах	III улирал	ХХААГ	-	-		Аймгийн хэмжээнд байгаа зoorь, үгрэм агуулахад аж ахуйн нэгж, иргэдийн хөрөнгийн эх үүсвэрээр ариутгал, халдваргүйжүүлэлт хийлгэх ажлыг зохион байгуулж, хяналт тавина. Үрийн улаан буудай болон төмсний үрэнд сортын хянан баталгаа хийнэ.

24.	Намрын ургацаас чанар сайтай үрийн болон хүнсний буудайн нөөц бүрдүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, нөөцийн агуулах, элеваторын бэлэн байдлыг хангах, үрийн болон хүнсний улаан буудайд хяналт шинжилгээ хийх	III, IV улирал	ХХААГ, ОБГ сумдын ЗДТГ	-	-	Хянан баталгаа болон лабораторийн шинжилгээгээр баталгаажсан үрийн буудайг ирэх оны тариалалтад нөөцлөх чиглэлээр аж ахуйн нэгж, иргэдтэй хамтран ажиллана. Хяналт тавина.
25.	Ургац хураалтын үед ашиглагдах жин хэмжүүр, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтыг хийх	III улирал	СХЗХ			Үтрэм болон өрхийн тариаланчдад хэрэглэж буй жин хэмжүүрт улсын байцаагчаар баталгаажуулалт хийлгэх ажлыг зохион байгуулна. Нийт 5 үтрэм, ургац захын хэмжүүр хамрагдана.
26.	Ургац хураалтын явцад тариаланчдыг цаг агаарын урьдчилсан мэдээ, мэдээллээр тогтмол хангах, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх	I, II, III улирал	УЦУОШТ, ХХААГ, сумдын Засаг дарга нар	-	-	ОБГ, УЦУОШТ-өөс цаг агаарын мэдээг тогтмол авч сумдын ЗДТГ болон ХХААГ-ын раге хаягаар шуурхай хүргэх ажлыг зохион байгуулна.
27.	Ургац хураалтын ажилд оюутан, цэргийн албан хаагчдыг татан оролцуулах ажлыг зохион байгуулах, тэдгээрийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллах	III улиралд	ХХААГ, ЦШ, БШУГ, ХХҮГ	-	-	Ургац хураалтад шаардагдах хүн, хүчний судалгааг гаргаж БШУГ, ХХҮГ, ЦШ-т хүргүүлэх ажлыг зохион байгуулна.
28.	Ургацыг малаас хамгаалах, ургац хураалтын ажил дуусах хүртэл тариалангийн талбайн ойр орчимд мал бүхий иргэдийг буулгахгүй, малыг хариуллага, маллагаатай байлгах зохион байгуулалтын арга хэмжээ авах	II, III улирал	Сумдын ЗДТГ, ЦГ	-	-	Жаргалант сумын Засаг даргын захирамжаар 2023 оны 11 сарын 01-ийг хүртэл хугацаанд тариалангийн талбайд мал оруулахгүй, тариалангийн бүсэд байгаа малыг байнгын маллагаатай байлгах арга хэмжээг зохион байгуулна.
29.	Ургац хураалтын ажлын явц болон үр дүнг олон нийтэд хүргэх, тариалангийн салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнг сурталчлах чиглэлээр хамтран ажиллах	III, IV улирал	ХХААГ, сумдын ЗДТГ	-	-	Орон нутгийн ТВ болон ХХААГ-ын раге хаягаар иргэдэд хүргэх, аймаг сумдын ургацын баяр зохион байгуулна.



30.	Үр тариа, төмс, хүнс ногооны тээврийг саадгүй нэвтрүүлэх, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор улсын чанартай зам, гүүрэн дээр цагдаагийн эргүүл пост ажиллуулах	III улирал	ЗЦТ	-	-	Аймгийн ЦГ, Жаргалант сумтай хамтран шаардлагатай цэгүүдэд Цагдаагийн пост гаргах ажлыг зохион байгуулна.
31.	Төмс, хүнсний ногооны борлуулалтыг дэмжих, орон нутгийн иргэдийг хямд үнэтэй, чанартай ногоогоор хангах зорилгоор төмс, хүнсний ногооны борлуулалтын Цэг ажиллуулах, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	III улирал	ХХААГ, сумдын ЗДТГ		ОНТ	Аймгийн иргэдийн хэрэгцээнд шинэ ургацын төмс хүнсний ногоо нийлүүлэх зорилгоор Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт зөвшөөрөгдсөн цэгт өргөтгөсөн худалдааг зохион байгуулна. Аймгийн болон улсын "Алтан намар" үзэсгэлэн худалдаанд тариаланчдыг оролцуулж борлуулалтыг дэмжиж ажиллана.
<b>Дөрөв.Хүнсний чиглэлээр:</b>						
32.	Хүн амын хаврын хэрэгцээнд зориулан махны нөөц бүрдүүлж ажиллах	I, II, IV улирал	Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ, ХХААГ	600,0	ОНТ	Хүнсний тухай хуульд заасны дагуу стратегийн хүнс болох махны нөөц бүрдүүлж иргэдийг хаврын улиралд үйлдвэрийн аргаар бэлтгэсэн, хямд үнэтэй махаар хангах ажлыг зохион байгуулна. Үхрийн 100 тн, хонины 80 тн, ямааны 20 тн, нийт 200 тн мах нөөцөд бүрдүүлнэ. 1 кг маханд 2500-3000 төгрөгийн татаас урамшуулал олгохоор тооцсон. 2024 оны орон нутгийн төсөвт суулгах саналтай байна.
<b>Нийт дүн</b>				<b>924,1</b>	<b>сая/төг</b>	